

“САНХҮҮГИЙН ХҮРТЭЭМЖИЙН НИЙГЭМЛЭГ” /AFI/ ХҮРТЭЭМЖИЙН НИЙГЭМЛЭГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНООС ОРОЛЦОЖ БУЙ БАЙДАЛ

2015 оны 10 дугаар сарын 28

1. Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг (СХН)

Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэгт өнөөгийн байдлаар дэлхийн хөгжиж буй 95 орнуудын 119 гишүүн байгууллагууд /санхүүгийн зохицуулах байгууллага, төв банк/ гишүүнчлэгдэж, дэлхийнбичил санхүүгийн 85 хувийг хамарсан,хөгжиж буйболонхөгжингүй орнуудын санхүүгийн бодлого боловсруулагчдийг хамруулсан, ядуу буурай хүн амд санхүүгийн үйлчилгээг хэрхэн ойртуулах тал дээр анхаарал хандуулан ажилладаголон улсын байгууллага бөгөөд санхүүгийнхүртээмжийн бодлого боловсруулагчдад зориулсандэлхийн хамгийн анхнысургалтын даяарчлагдсан (глобал) платформ, бодлого боловсруулагчдын дэлхийн сүлжээ байгууллага юм.

Холбоо нь үндсэн үйл ажиллагааныхаа хүрээнд гишүүн байгууллагуудын дунд санхүүгийн үйлчилгээг ядуу иргэдэд хүртээмжтэй болгоход чиглэгдсэн мэдлэг, туршлага солилцох, тулгарсан асуудлыг шийдвэрлэх арга зам хайх зэрэг зорилгоор чиглэл бүрийн ажлын хэсэг байгуулан ажилладаг.

Тус Холбоо нь Билл болон Мелинда Гейтсийн сан (Bill and Melinda Gates Foundation)-аас санхүүжигдахаар 2008 оны 9 дүгээр сард үүсгэн байгуулагдаж, Германы хамтын ажиллагааны нийгэмлэг ([The German International Cooperation \(GIZ\)](#)) нь удирдлагыг гишүүн байгууллагуудын нэрийн өмнөөс хэрэгжүүлж байна.

Энэхүү Холбооны сүлжээнд хамрагдсан 95 орнуудад дэлхийн 2,5 тэрбум банкны үйлчилгээ авч чаддаггүй (unbanked) иргэдэд санхүүгийн үйлчилгээг ойртуулах, санхүүгийн хүртээмжийн шинэчилсэн бодлогыг тодорхойлох, хөгжлийг түргэтгэхэд чиглүүлэн гишүүдээ арга хэрэгсэл болон эх үүсвэрээр хангах, тэдний өндөр зэрэглэлийн мэдлэг дээрх санхүүгийн хүртээмжийн бодлогыг хөгжүүлэх, хэрэгжүүлэхэд хамтран ажиллаж байна.

Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэгээс гишүүн байгууллагуудын дунд жил бүр Дэлхийн бодлогын Чуулган, Ажлын хэсгийн уулзалтууд, Гишүүдийн хамтарсан сургалтууд, Сэдэвчилсэн семинаруудыг тогтмол зохион байгуулдаг. Мөн санхүүгийн үйлчилгээ, хүртээмжийн талаар мэргэшсэн зөвлөх үйлчилгээгээр хангах, олон улсын санхүүгийн үйлчилгээний сайн туршлага бүхий бодлоготой танилцах, чадавхи сайжруулах, бодлогын болон мэдлэг солилцох тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдах боломжтой байдаг.

Ажлын хэсгүүд болох “Санхүүгийн хүртээмж, тогтвортой байдал ба ёс зүйн тэнцвэртэй байдал” “Хэрэглэгчийн эрх ашиг ба зах зээлийн ёс зүй”, “Цахим санхүүгийн үйлчилгээ” “Санхүүгийн хүртээмжийн стратеги”, “Санхүүгийн хүртээмжийн үнэлгээ”, “ЖДҮ-ийн Санхүүгийн үйлчилгээ”, эдгээрээс СЗХ “Цахим санхүүгийн үйлчилгээ” “ЖДҮ-

ийн Санхүүгийн үйлчилгээ” ажлын хэсгийн идэвхитэй гишүүний хувиар Монгол Улсад анх удаа Цахим үйлчилгээний төрөл болох “Мобайл банк”-ны үйлчилгээг хэрэгцүүлж “Цахим мөнгөний үйлчилгээний журам”-ыг 2011 оны 12 дугаар сард батлан гаргах, 2014 оноос хэрэгжиж буй “Хөдөө аж ахуйн бараа таваарын биржийн үйл ажиллагааг олон улсын түвшинд хүргэх” төслийн ажлуудыг гүйцэтгэж байна.

Гишүүн байгууллагын хүртэх үр ашиг

- Гишүүдийн бодлогын сүлжээ болон стратегийн партнеруудын сүлжээнд холбогдох боломж /техникийн эксперт, хамтарсан донор байгууллагууд, судалгааны байгууллагууд болон хувийн салбар/;
- Санхүүгийн хүртээмжийн бодлогод хамрагдах;
- Санхүүгийн хүртээмжийн шинэчилсэн бодлогыг идэвхжүүлэх чиглэлээр тухайн ажлын хэсэгт хандан бүцэлтгүй тусламж хүсэх;
- Мэдлэг солилцох, харилцан суралцах хөтөлбөрт оролцох;
- Гишүүдийн хүрээнд оролцох, /платформд нэвтэрч мэдлэг, нөөцөө хуваалцах санхүүгийн хүртээмжийн бодлого боловсруулагчдын платформ/;
- Санхүүгийн хүртээмжийн бодлогын амжилттай хэрэгжсэн судалгаа, ололтуудыг олж авах;
- Жил бүрийн Даяарчлагдсан бодлогын уулзалт /**Global Policy Forum**/-д оролцох болон бусад бус нутгийн семинарт уригдах боломж;
- Шилдэг бодлогын шалгаруулалтад оролцох, олон улсад хөгжүүлсэн мэдлэгийн бүтээгдэхүүнийг урамшуулах;
- Удирдах зөвлөлд нэгдэж G20 гэх мэт олон улсын түвшинд **Холбоог** төлөөлөх боломж /зөвхөн үндсэн гишүүдэд нээлттэй /.

2. “Санхүүгийн хүртээмжийн талаарх МАЯАГИЙН ТУНХАГЛАЛ” /MAYA DECLARATION. The AFI network commitment to financial inclusion/-ын талаар

Энэхүү тунхаглал нь СХН-ийн үндсэн бичиг баримт юм. Мексикийн Ривьера-Маяад 2011 онд зохион байгуулагдсан Даяарчлагдсан бодлогын уулзалт /Global Policy Forum/-ын үеэр 65 орны 90 гишүүд байгууллага, 180 гаруй нөлөө бүхий улс төрчид өнгөрсөн хугацаанд бий болсон, тулгамдсан асуудлуудыг хэлэлцэж, хүртээмж бүхий санхүүгийн салбарын шинэ хандлага, арга замыг бий болгох чиглэлээр хамтарсан амлалт бүхий “Санхүүгийн хүртээмжийн талаарх Маяагийн тунхаглал”-ыг баталсан. Тус тунхаглалд дараах 4 зарчмыг тусгасан.

1. Санхүүгийн үйлчилгээг боломжийн өртгөөр хүргэх таатай орчныг бүрдүүлэх, санхүүгийн үйлчилгээний нэгжийн өртгийг үлэмж бууруулах, шинэ технологийн бүрэн хэрэглээг бий болгох бодлогыг боловсруулах;
2. Тогтвортой, бүрэн бүтэн, хүртээмжтэй санхүүгийн салбарыг бий болгох зорилгыг хангах зохицуулалтын бүтцийг бий болгох;
3. Бүхий л иргэд санхүүгийн салбарын үйлчилгээг авдаг болгох зорилгоор хэрэглэгчийг хамгаалах, эрхээ хэрэгжүүлэх боломжийг бий болгох;
4. Дэлгэрэнгүй мэдээллийг цуглуулах, шинжлэх замаар санхүүгийн хүртээмжийн хандлагын өөрчлөлтийг харуулсан, холбооны түвшинд харьцуулагдахуйц үзүүлэлтүүд бүхий нотолгоонд үндэслэсэн санхүүгийн хүртээмжийн бодлогыг эхний ээлжинд боловсруулах.

3. Монгол Улсад цахим мөнгөний үйлчилгээг нэвтрүүлэх төслийн хэрэгжилтийн талаар

Монгол улс газар зүйн байршлын хувьд аймаг, сумууд нь алслагдмал, өргөн уудам нутагт тархай бутархай суурьшсан, цөөн хүн амтай, хөдөөгийн иргэд санхүүгийн үйлчилгээ авахын тулд ойролцоогоор 50-300 км замыг туулдаг, өрх, иргэн бүрийг санхүүгийн үйлчилгээнд бүрэн хамруулах, тэдэнд санхүүгийн үйлчилгээг хямд зардлаар, хурдан, шуурхай хүргэх буюу санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх нь тулгамдсан асуудал байсаар ирсэн.

Энэхүү төслийн хүрээнд зохицуулагч байгууллага /СЗХ, Монголбанк, ХХЗХ/-ын ажилтнууд болон удирдлагууд цахим мөнгөний үйлчилгээний бодлого, зохицуулалтын талаар шинэ мэдлэг, мэдээлэл олж авсан төдийгүй хөрөнгө санхүүгийн эх үүсвэргүйн улмаас шийдвэрлэж чадахгүй байсан олон асуудлыг шийдвэрлэсэн.

Түүнчлэн олон улсын зөвлөх ажиллаж, санхүүгийн шинэ бүтээгдэхүүн болох цахим мөнгөний талаар баримтлах бодлого, чиглэл, зохицуулалтыг боловсронгуй болгох санал, зөвлөмж гаргасан нь санхүүгийн үйлчилгээний цар хүрээ, хүртээмжийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдол болсон.

Төсөл хэрэгжсэнээр дараах үр дүнд хүрсэн.

1. Цахим мөнгөний бодлого, зохицуулалтыг боловсронгуй болгох чиглэлээр:
 - Цахим мөнгөний болон мобайл банкны талаар баримтлах бодлогын талаарх эрх зүйн орчинг боловсронгуй болгох ажлын хэсэгт санал хүргүүлсэн;
 - Төлбөр тооцооны үндэсний зөвлөлд цахим мөнгөний нэгдсэн системтэй байх асуудлыг дэвшүүлж, нэгдсэн зохицуулалт, хяналт хийх тухай саналаа хүргүүлсэн;
 - Зөвлөхийн өгсөн санал зөвлөмжийн дагуу түр журамд нэмэлт өөрчлөлт оруулж, байнгын журам болгохоор төслийг боловсруулаад байна.
2. Хяналт шалгалтыг боловсронгуй болгох чиглэлээр

- Цахим мөнгөний үйлчилгээ үзүүлэгч “Мобифинанс ББСБ” ХХК-ийн цахим мөнгөний гүйлгээг тухай бүрд нь хянах, программ хангамжийг сайжруулах талаар тус компанитай зөвшилцөн бэлтгэл ажлыг хийж байна;
- “Мобифинанс ББСБ” ХХК-ийн сар тутмын санхүүгийн тайланг хүлээн авч үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг хангаж ажиллаж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллаж байна.

3. Бусад чиглэлээр

- Бизнесийн байгууллагууд энэ үйлчилгээг сонирхох хандлага нэмэгдэж эхэлсэн;
- Төрийн байгууллагууд энэ үйлчилгээний талаар санал солилцож, нэг шийдэлд хүрэх талаар зөвшилцаж эхлээд байна;
- Иргэд цахим мөнгөний үйлчилгээний талаарх ойлголт, мэдлэгтэй болж байна;
- Энэхүү үйлчилгээний төлөөлөгчөөр ажиллахаар 12 ББСБ гэрээ байгуулж, үйл ажиллагаагаа идэвхжүүлж байна.

4. Цахим мөнгөний үйлчилгээ үзүүлэгч “Мобифинанс ББСБ” ХХК-ийн чиглэлээр

- 2011 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар Монгол орны 21 аймагт цахим мөнгөний үйлчилгээ бүрэн нэвтэрч харилцагчдын тоо 45000 гаруй, гэрээт хамтрагчдын тоо 700 гаруй, төлөөлөгчдийн тоо 250 гаруйд хүрч өссөн байна;
- Цахим мөнгөний үйлчилгээг ашиглан зарим ББСБ-ын зээл, зээлийн хүү болон даатгалын хураамжийг төлөх боломжтой болж Капитал банкаар дамжуулан олгож буй Хүний хөгжил сангийн мөнгийг авч байна.¹ “

4. Гишүүнчлэлийн үүрэг хариуцлага:

- Өөрийн байгууллагын төлөөний хүнийг томилох. Тус төлөөлөгчийг орлох хүнийг томилох
- Хэлэлцүүлэгт оролцох (биеэр эсвэл онлайн хэлбэрээр) эсвэл ажлын хэсгийн зорилтот ажлуудад хувь нэмэр оруулах
- ЖДҮ-ийн санхүүжилттэй холбоотой бусад гишүүн орнуудын хийж буй ажлын хэсгийн зорилтот нийцсэн үйл ажиллагаанд өөрийн хувь нэмэр оруулах
- ЖДҮ-ийн хөгжил, санхүүгийн үйлчилгээний талаарх өөрийн орны нөхцөл байдлын талаар бусад гишүүдэд мэдээлэл өгөх
- Ажлын хэсгийн гишүүнчлэлийг бэхжүүлэхтэй холбогдуулан боломжит хамтран ажиллах сувгийн талаар бодит зөвлөгөө өгөн хамтран ажиллах
- Үйлчилгээний талаар санал хүсэлтээ ирүүлж байх

¹ СЗХ-ноос 2011 онд гаргасан “Мэдлэг солилцох тэтгэлэгт төсөл”-ийн хэрэгжилтийн тайлан”-аас авав.

- Ажлын хэсэгтэй зөвшилцсөний үндсэн дээр бусад байгууллагатай харилцаа тогтоох.

5. СЗХ-оос одоогийн байдлаар хийгдэж буй ажил

-СХН-ийн Гишүүн орнуудын ЖДҮ-ийн санхүүгийн үйлчилгээний ажлын хэсгийн уулзалтыг 2016 оны 5 сард Монгол банктай хамтран зохион байгуулах эрхийг авсан;

-“Хөдөө аж ахуйн бараа таваарын биржийн үйл ажиллагааг олон улсын түвшинд хүргэх” мэдлэг солилцох төслийн гүйцэтгэлийн ажил;

-СХН-ээс гишүүн орнуудад зохион байгуулдаг санхүүгийн хүртээмжийн сургалт, судалгааны ажлуудад идэвхитэй оролцох, байр сууриа илэрхийлэх;

- Монгол Улсын Санхүүгийн хүртээмжийн стратеги боловсруулах;

- Санхүүгийн боловсрлын стратеги боловсруулах;

-Банк бус санхүүгийн байгууллагуудын зохицуулалтын туршлага судлан нэвтрүүлэх.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО